



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ

# БОЛОВСРОЛ СУДЛАЛ

МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ

“Боловсрол судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийн  
энэхүү дугаарыг сэтгүүлийн редакцийн зөвлөлөөс  
эрхлэн гаргав.

ISSN-1818-8478

2018 Дугаар 21 (503)

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

# БОЛОВСРОЛ СУДЛАЛ

## № 21 (503)

<http://setguul.num.edu.mn>

Улаанбаатар хот

2018 он

## **Боловсрол судлал**

**№ 21 (503)**

### **Сэтгүүлийн зөвлөл:**

Б. Баяртготх Ph.D проф  
Б. Отгонтөгс Ph.D проф  
Ч. Лхагважав Ph.D дэд проф  
Ц. Даржаа Ph.D проф  
Ж. Даваа Ph.D проф  
Д. Амартүвшин Ph.D

МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын багш

### **Редакцийн зөвлөл:**

Amy B.M. Tsui Prof  
Yurawal Klaimongkol Ph.D  
Ц. Бурмаа Ph.D дэд проф  
Р. Чандалдулам Ph.D  
А. Амаржаргал Ph.D  
Н. Нэргүй Ph.D  
Б. Бурмаа Ph.D  
Н. Оюунцэцгээр Ph.D проф  
Ц. Даржаа Ph.D проф  
Ж. Даваа Ph.D проф  
Ч. Лхагважав Ph.D дэд проф  
М. Ганбат Магистр  
М. Итгэл Ph.D проф  
Д. Түмэнбаяр Ph.D  
Ц. Навчaa Магистр  
Г. Юмчмаа Ph.D дэд проф  
Д. Амартүвшин Ph.D  
Б. Алтангэрэл Ph.D проф  
Ш. Оюунгэрэл Ph.D дэд проф  
Г. Нандинбилэг Ph.D проф  
Ч. Бямбаханд Ph.D

The University of Hong Kong, Faculty of Education  
Chulalongkorn University, Faculty of Education  
МУБИС, хөтөлбөрийн нэгдсэн албаны дарга  
ХААИС, Бакалаврын хөтөлбөрийн албаны дарга  
ХУИС, Бизнесийн сургуулийн захирал  
МУИС, МДССТ-ийн судлаач  
МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын зөвлөх профессор  
МУИС-ШУС-ын багш  
МУИС-ШУС-ын багш

Цаасны хэмжээ: А4

Хэвлэгдсэн тоо: 100 ш

Хэвлэлийн хуудас: 6 х.х.

ISSN: 1818-8478

# Гарчиг

## 21 ДУГЭЭР ЗУУНЫ МОНГОЛ СУРАЛЦАГЧИЙН КОМПЕТЕНЦИЙН “ТООНОН” ЗАГВАР

*H.Oюунцэцэг, H.Норжсхорлоо, D.Сарангэрэл .....* 4-14

## ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ ДАХЬ ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦОOG ХЭМЖИХ ЗАГВАРЫН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

*D.Tүмэнбаяр, B.Отгонжаргал, D.Цэцэгдэлгэр .....* 15-22

## BUSINESS DECISION MAKING AND SPATIAL DATA ANALYSIS WITH GIS

*D.Chimgee, J.Erdenechimeg, S.Oyunsuren, A.Bolor .....* 23-31

## IMPLEMENTING PROCESS WRITING METHOD IN TRADITIONAL CLASS

*D.Myagmarsuren .....* 32-38

## ОЮУТНУУДЫН СУРГАЛТ УДИРДАХ СИСТЕМИЙГ ЦААШИД ХЭРЭГЛЭХ ЗОРИЛГОД НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ ДЭХ БҮЛГИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

*Ц.Навчaa .....* 39-47

## **21 ДҮГЭР ЗУУНЫ МОНГОЛ СУРАЛЦАГЧИЙН КОМПЕТЕНЦИЙН “ТООНОН” ЗАГВАР**

Ноокоогийн Оюунцэцг<sup>1</sup>, Намралын Норжхорлоо<sup>2</sup>, Даваасамбуугийн Сарангэрэл<sup>1</sup>

<sup>1</sup>*Монгол Улсын Их Сургууль, Шинжслэх Ухааны Сургууль, Химийн тэнхим*

<sup>2</sup>*Багийн Мэргэжил Дээшилүүлэх Институт*

### **Abstract**

*The article aims to present the 21<sup>st</sup> century competence model of Mongolian learners which was developed by the comparative analysis of related domestic and international documents, articles and reports. The developed competence model was named as “Toono model” which is origin from wooden circular frame of Mongol ger. The Toono model, which can be applied and adapted to the all education level programs from pre-school to tertiary education, was consisted of totally eight key competencies. Moreover, this model can be formulated as a learning outcome of units, courses and classes besides education level.*

## **Үндсэн агуулга**

“Тогтвортой хөгжлийн зорилго (TX3) 4-Боловсрол 2030 үйлийн хүрээ”-нд тодорхойлогдсон боловсролын хөгжлийн шинэ алсын хараанд чиглүүлэн дэлхий нийтэд боловсролоо хувирган өөрчлөх үйл явц эрчимжиж байна. 1992 оноос хойших олон улсын байгууллагуудын тунхаглалын чанартай баримт бичгүүдэд насан туршдаа суралцахуй, түүнд харгалзах компетенцийн талаар зөвлөсөн байдаг. Дэлхийн улс орнууд тэдгээр баримт бичгийн үзэл санаанд суурилан өөрийн орны онцлогтой боловсролын шинэчлэлийг хийж байна.

### *Онол, арга зүй*

#### *Насан туршийн боловсролын үзэл санаа*

1972 онд судлаач Эдгар Фор “Хүн болохын тулд суралцах нь: Өнөөдөр ба маргаашийн боловсрол” илтгэлдээ уламжлалт боловсролын систем бэрхшээлтэй тулгарсан цаг үед суралцаж буй нийгэм, насан туршийн боловсрол гэсэн хоёр холбоотой ойлголтыг гаргаж тавьсан байна ([Morgan W.J., 2013](#)). Тэрээр технологийн дэвшил, нийгмийн өөрчлөлт хурдассанаар хүний олж авсан анхны боловсрол түүний амьдралых нь туршид хангалттай гэж хүлээн зөвшөөрч болохгүй гэж дурьдаад, насан туршийн боловсролыг хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын боловсролын бодлогын тулгын чулуу гэж тодорхойлжээ ([ЮНЕСКО, 2017](#)).

1992 онд Рио-Де-Жанейрод “Хөгжлийн хөтөлбөр-21”-ийг батлан гаргаж, дэлхий дахиныг хамарсан хүн төрөлхтний шинэ зуунд мөрдөх хөгжлийн гол чиг баримжааг тодорхойлов ([Б.Хулдорж, 1999](#)). 1996 онд 21 дүгээр зууны боловсролын олон улсын комиссын ЮНЕСКО-ийн тайланд Ж.Делор ([Jacques Delors, 1996, Боловсрол: Түүнд нуугдсан эрдэнэс](#)) насан туршдаа суралцах тухай ойлголтыг санал болгосон нь шинэ зууны боловсролын түлхүүр үзэл санаа болсон байна ([S Tawil, 2013](#)).

1999 онд ЮНЕСКО шинэ зууны боловсролын дээрх концепцийг дэмжиж, дэлхийн улс орнууд боловсролоо шинэчлэн хөгжүүлэх чиг баримжаа болох хэд хэдэн тунхаглалын баримт бичгийг дэвшүүлэн тавьсан юм. Мөн онд ЮНЕСКО болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ([ЭЗХАХБ-ОЕCD](#))-аас дэлхийн боловсролын шалгуур үзүүлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, зарим улс орны боловсролын байдалд дүн шинжилгээ хийжээ. Уг хөтөлбөрийн гол зорилго нь улс орнуудын Засгийн газарт боловсролын тогтолцоогоо сайжруулах чиглэлээр улс төр, захиргааны шийдвэр гаргахад ашиглаж болохуйц шалгуур үзүүлэлтийг санал болгосон байdag. ([UNESCO/OECD, 1999](#)).

2000 онд Дакарын болон Мянганы Тунхаглалд бүх нийтийн, чанартай боловсролын асуудлыг дэлхийн улс орнуудад тунхаглан зарласан бөгөөд ЮНЕСКО-оос боловсролын үндсэн зорилтыг Ж.Делорсын томьёолсон суралцахуйн 4 тулгуур баганын зарчим гэж үзэж баталсан байна ([UNESCO, 2000](#)).

2002 онд Өмнөд Африкийн Йоханнесбург хотноо болсон НҮБ-ын “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн Их чуулган” олон улсын Дээд хэмжээний уулзалт нь шинэ зууны хөгжлийн гол чиглэлийг тунхаглал хэлбэрээр гаргасан ([П.Очирбат ба бусад, 2004](#)).

2012 онд ЮНЕСКО-оос бүх хүүхэд, залуучуудад зориулан суралцах зайлшгүй чухал чиглэлийг тодорхойлох зорилгоор 70 гаруй орны 700 гаруй зөвлөх, судлаачид оролцож “Бүх нийтийн боловсролын төлөө” (Toward Universal Learning) нэртэй цуврал зөвлөмжийг

бэлтгэсэн юм. Цуврал зөвлөмжид бүх хүүхэд, залуучуудын сургалтад юу чухал ач холбогдолтой вэ?, Сургалтын үр дунг хэрхэн хэмжих вэ?, Боловсролын чанарын хэмжих аргыг яж сайжруулах вэ? гэсэн асуултыг дэвшүүлж дэлхий нийтийн анхаарлыг хандуулсан ([UNESCO, 2013](#)).


Бразил Улсын Рио де Жанеро хотноо 2012 онд чуулсан Рио+20 НҮБ-ын бага хурлаас баталсан “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичиг, шийдвэрийн дагуу даян дэлхийн тогтвортой хөгжлийг тодорхойлж боловсруулах үүрэг бүхий нээлттэй ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд 17 үндсэн зорилгыг хамрах 169 зорилтод хүрэх “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ыг боловсруулж, Ассамблейд өргөн барьсан юм. Олон удаагийн, урт хугацааны хэлэлцүүлгийн үр дүнд 2015 оны 8 дугаар сард НҮБ-ын гишүүн 193 орны нэгдсэн шийдвэрээр Мянганы хөгжлийн зорилгын үнэлгээнд суурисан, бүх улсыг хамарсан, ядуурлыг устгах, эх дэлхий, байгаль орчноо хамгаалах, хүний тайван амгалан амьдрах эрхийг хангах зэрэг өргөн хүрээний асуудлыг багтаасан “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр” (togtвортой хөгжлийн зорилго-2015-2030) батлагдан гарсан. ([ЮНЕСКО, 2015](#)). Энэхүү ТХБ-4 зорилт нь “Бүгдийг хамарсан, нийтлэг, чанартай боловсрол олгох, амьдралын турш сурх боломжийг дэмжих”-ийг заасан болно.

2016 онд Хүмүүс, гараг дэлхийн төлөөх боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх, Боловсролын хяналт, үнэлгээний дэлхийн тайланг гаргасан. Энэхүү тайланд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго (TX3 4) ялангуяа үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшинд бодлогын өөрчлөлтөд гарч буй ахиц дэвшилд хяналт, үнэлгээ хийхэд тулгарч буй сорилтыг авч үзсэн байна ([ЮНЕСКО, 2016](#)).

#### *Компетенцийн онол, загвар*

1953 онд АНУ-ын менежментийн салбарт тэргүүлэгч Д.МакКеланд анх удаа хүний зан чанарын талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлж, компетенци гэж нэрлэсэн билээ. 1959 онд Р.Вайт, хожим нь МакЛаган, Р.Бояцис, С.Спенсер, Д.Улрих нар байгууллагын оршин тогтнох, өрсөлдөөний давуу талыг тогтвортой байлгах компетенцийн концепцийг цаашид хөгжүүлсэн. 1973 онд Харвардын их сургуулийн сэтгэл судлаач, профессор Д.МакКеланд ([McClelland, 1973](#)) “Үйлдвэрийн сэтгэл судлалын салбарт оюун ухаанаас илүүтэй компетенцийг шалгах нь” гэсэн судалгааны өгүүлэлдээ уламжлалт академик мэдлэг, чадвар болон тэдгээрийг шалгах гүйцэтгэлийг, зарим тохиолдолд тухайн ажлын гүйцэтгэлийг илэрхийлэхэд сайн тохиордог гэж үзжээ. МакКеланд 1973, 1998 онд хийсэн ажлаараа боловсролын салбар дахь компетенцийн загварын хэрэглээнд гол анхаарлаа хандуулснаас гадна компетенцийн аргыг бага, суурь, дээд боловсрол, байгууллагын судалгаа зэрэг янз бүрийн салбарт буулган, хэрэглэж чадсан байна.

МакКеланд компетенцийг мөсөн уулын загвар (Зураг 1)-аар тодорхойлж, мөсөн уулын гүехэн ил хэсэгт хүний мэдлэг, чадварыг, мөсөн уулын ихэнх хэсэг буюу гүн, гүнзгий хэсгээр өөрийн үзэл санаа (self-concept), эрхэмлэдэг зүйлс (values), зан араншин (traits), мөс чанар (personality) урам зориг (motives), ёс суртахуун (ethics) зэрэг хүмүүний араншиг төлөөлүүлсэн байдаг ([McClelland, 1973](#)).



*Зураг 1. Компетенцийн мөсөн уулын загвар*

1982 онд Р.Бояцис тухайн ажлыг бүтээмж өндөртэй, эсвэл маш өндөр чанартай гүйцэтгэж чадахуйц хүний зан чанар (урам зориг, зан араншин, чадвар, өөрийн төсөөлөл эсвэл нийгмийн үүрэг, мэдлэг)-т суурилсан компетенци (competency)-ийг томьёолжээ ([Boyatzis, R. E., 2008](#)).

Спенсер нар Бояцисийн ажлыг үргэлжлүүлэн тухайн ажил эсвэл нөхцөл байдалд шалгуурт суурилсан бүтээмж өндөртэй эсвэл дээд зэргийн чанартай гүйцэтгэлийг үзүүлж чадах хувь хүний зан чанар болон компетенци (competency)-ийг томьёолсон ([Spencer, 1993](#)).

Сүүлийн жилүүдэд компетенци (competence болон competency) нэр томъёоны түгээмэл хэрэглээ бий болж, олон утга санаа, шинэ тэмдэглэгээнүүд гарч ирж байна ([Strebler et al., 1997](#)). Компетенци (competency) нь хувь хүний харуулах шаардлагатай зан төлөв байдлаар илэрхийлэгддэг бол компетенци (competence) нэр томьёо нь гүйцэтгэлийн стандарт гэсэн утгаар түгээмэл илэрхийлэгддэг ([Hoffmann, 1999](#)).

компетенци (competency) гэдэг үг нь шүүх эрхтэй, ярих эрхтэй байх гэсэн утга илэрхийлэх “competentia” гэсэн латин үгээс гаралтай ([Caupin, et al., 2006](#)). Толь бичигт бичсэнээр компетенци (competence ба competency) үндсэндээ ижил утгатай байдаг: Компетенци (Competence) нэр үг: а. Хангалттай, сайн мэргэшсэн эсвэл чадвартай байх төлөв, чанар, б. Тодорхой чадвар, мэдлэг, чадамж ([American Heritage Dictionary, 2006](#)). Компетенци (Competency) нэр үг: Бие махбодын болон оюун ухааны хувьд хангалттай эсвэл сайн мэргэшсэн байх чанар ([WordNet, 2006](#)).

Судлаачид компетенцийг янз бүрээр тодорхойлж ирсэн байдгийг он дарааллаар нэгтгэн харуулж байна. Үүнд:

- МакЛеланд (1973) competence—Маш бүтээмжтэй, дээд зэргийн сайн гүйцэтгэлтэй хийх хүний хувийн зан араншин эсвэл дадал
- Клемп (1980), Бояцис (1982, 2007) competency – Ажлыг бүтээмжтэй, дээд зэргийн гүйцэтгэлтэй хийж чадах хүний онцлог чанар
- Якобс (1989) competency – Тухайн даалгаврыг амжилттай дуусгаж чадах ажиглагдахуйц чадвар
- Хогг (1989) competencies – Тухайн салбартаа бүтээмж сайтай гүйцэтгэл үзүүлж чадах чадвар, чадамжийн цогц, түүнчлэн нэг салбараас нөгөө рүү чадвар, чадамжийг дамжуулах чадавхитай хамааралтай.
- Спенсер нар (1993) competencies – Ажил, амьдралын туршлага, сургалт, семинараар олж авсан тухайн зүйлийг хийх чадвар, чадамж
- Гилберт (1996) competence – Зорилгоо биелүүлэхэд хамгийн бүтээмжтэй, үр ашигтай үр дүн гарган авах чадвартай холбоотой өрсөлдөөнтэй байх төлөв
- Дубос (1998) competencies – Аливаа зүйлд амжилттай гүйцэтгэлтэй байх дангаараа болон хосолж хэрэглэдэг мэдлэг, чадвар, сэтгэлгээ зэрэг онцлог чанар
- Вүүдл, Винстанли (1998) competency – өгсөн контекст, нөхцөл байдалд үүргийн гүйцэтгэл бүтээмж өндөртэй байх мэдлэг ойлголт, чадвар, чанар, үнэт зүйл, итгэл найдвар, хандлагын цогц
- Теодереску, (2006) competence—тухайн зорилгыг хамгийн бүтээмжтэй хэрэгжүүлэхэд шууд чиглэсэн гүйцэтгэл (Teodorescu, 2006).

Дээрх судлаачдын тодорхойлолтоос нэгтгэн дүгнэхэд компетенци (competency/competencies) нь тухайн байгууллагын тусгай ажил, үүргийг гүйцэтгэж амжилттай үр дүн гаргахад шаардагдах амжилтын хүчин зүйлийн цуглуулга юм. Эдгээр амжилтын хүчин зүйлүүд нь хамгийн сайн гүйцэтгэгчийн харуулж чадах, тусгай төрх байдлаар тодорхойлогдох мэдлэг, чадвар, чадамжийн нийлэмж байдаг. Ийнхүү судлаачдын судалгааны үр дүнгээс бид монгол суралцагчийн компетенцийн загвар боловсруулахад компетенци (competency)-ийг ойлгож байна гэж үзэж тодорхойллоо.

Компетенцийн загвар нь тухайн ажил (work)-ын контекстэд шалгарсан гүйцэтгэл үзүүлэхүйц зан төлвөөр тодорхойлогдох хүчин төгөлдөр, ажиглагдахуйц, хэмжигдэхүйц мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг хэлнэ. Компетенцийн загвар нь тухайн үүргийг хамгийн сайн гүйцэтгэхэд шаардагдах түлхүүр зан төлвийг багтаасан компетенцийн багц юм ([Vikram S.C. etc, 2014](#)). Компетенцийн загварыг бүтээхдээ компетенци бүртэй холбоотой үйл ажиллагаа, төрх байдлын тодорхойлолтыг багтаасан, компетенцуудийн уялдаа, холбоог харуулсан байх ёстой.

21 дүгээр зууны компетенцид юу багтах вэ, цаашид улам хурдацтай өөрчлөгдөх, өрсөлдөөнтэй, даяарчилагдсан нийгэмд хүүхэд, залуучууд ямар компетенциудыг зайлшгүй эзэмших шаардлагатай вэ гэсэн асуултад дэлхийн олон улсын байгууллага болон улс орнууд эрэл хайгуул хийж, зарим хариулт-загваруудыг гаргаж ирсэн байна. Тухайлбал, ЮНЕСКО-гийн 21 дүгээр зуунд глобаль түвшинд бүх хүүхэд, залуучуудын эзэмших суралцахуйн 7 ай ([Learning Domains, UNESCO, 2013](#)), ЮНЕСКО-ийн Бангкок дахь Ази-Номхон далайн орнуудын Боловсролын судалгааны институтын сүлжээ ([Asia-Pacific Education Research Institutes Network](#)) байгууллагын улс орон бүр 21 дүгээр зуунд өөрийн онцлогт буулган хэрэглэж болох “Transversal competencies” ([UNESCO, ERI-Net, 2013](#)), 21

дүгээр зууны сургалтын түншлэлийн холбоо (Partnership for 21st Century Learning, or P21)-ны компетенцийн “Солонгон загвар” (The 21st Century Knowledge-and-Skills Rainbow, ), ЭЗХАХБ (OECD DeSeCo)-ын түлхүүр компетенцийн 3 категори (OECD, 2005,Competency Category), Европын комиссын Боловсрол, Соёлын газар (European Commission's Directorate-General for Education and Culture)-ын Насан туршийн суралцахуйн түлхүүр 8 компетенци (European Union, 2006), Канадын Онтарио мужийн компетенцийн загвар (21st Century Competencies for Ontario, 2012) зэргийг дурдаж болно.

### **Судалгааны материал, арга зүй**


Судалгааны ажлын хүрээнд компетенци нэр томьёоны үүсэл, түүхэн хөгжлийн тоймыг авч үзэж улмаар компетенцийг илэрхийлдэг үндсэн ухагдахуун, нэр томьёог хэрхэн авч үзэж байгаа талаар тайлбарлаж; олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын тунхаглалын болон боловсролын чанарын үнэлгээний олон улсын хөтөлбөрийн 1992 оноос хойшихи баримт бичгүүдтэй танилцан 21 дүгээр зууны монгол суралцагчийн компетенцийн гол үзэл санааг тоймлон гаргалаа. Судалгаанд хамрагдсан хэвлэлийн тоймоос олон улсын судалгааны байгууллагуудаас дэвшүүлсэн компетенцийн загваруудыг тусгайлан авч үзсэний зэрэгцээ зарим улс орны суралцагчиддаа эзэмшүүлж буй компетенци, тэдгээрийн загварыг жишээлэн авч үзлээ.

Мөн зарим улс орны үндэсний хөтөлбөр дэх компетенцийн үзэл баримлал, загвар, тэдгээрийг боловсролын түвшин бүрт хэрхэн буулган боловсруулсан туршлага, өөрийн орны ерөнхий боловсролын шинэчлэлийн хүрээнд 2004 оноос хойш хэрэгжүүлсэн үндэсний стандарт, хөтөлбөрүүдийг судлах замаар компетенцийн хөгжлийн өнөөгийн байдал зэргийг тоймлон судаллаа. “Компетенци” гэдэг үгийн утга учрыг дэлхий нийтээр түгээмэл хэрэглэдэг 5 тайлбар толь болон судлаачдын тодорхойлолтыг 9 хэвлэлийн тоймоос харьцуулж харуулсан. Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын тунхаглалын, боловсролын бодлого, боловсролын чанарын үнэлгээний баримт бичгүүд, улс орнуудын болон манай орны үндэсний стандарт, сургалтын хөтөлбөр дэх компетенцийн үзэл баримлал, загвар зэрэг 200 гаруй баримт бичгийг харьцуулан судалсан болно.

### **Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг**

Бид компетенцийн загварыг бүтээхдээ компетенци бүртэй холбоотой үйл ажиллагаа, төрх байдлын тодорхойлолтыг багтаасан, компетенцуудийн уялдаа, холбоог харуулсан байхад анхаарсан билээ. Компетенцийн загварыг боловсруулахдаа мэдлэг, чадвар, хандлага нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байх шалгуурыг тооцож үзэн өөрийн орны онцлог, дэлхийн чиг хандлагыг баримтлан боловсролын бүх түвшинд инвариант хадгалагдан буулгах боломжтой 21 дүгээр зууны монгол суралцагчийн компетенцийн “тоонон” загварыг бүтээлээ. Тоононы дөрвөн жижиг чагтагад компетенцийн 4 багцийг, том дугуй чагтагад найман түлхүүр компетенцийг тус тус харгалзуулсан болно. Түлхүүр/үндсэн компетенци нь хувь хүний болон нийгмийн түвшинд амжилт гаргахад хувь нэмэр оруулах, нэгдмэл шаардлагыг хэрэгжүүлэх түүнчлэн янз бүрийн нөхцөл байдалд төвөгтэй шаардлага, сорилттой тулгарахад хэрэглэгдэх, хувь хүн бүрт ач холбогдолтой байх гэсэн шалгууруудыг хангасан байхаар боловсруулав.

Судалгааны дунд 1) хэл соёлын (хэлний, соёл түүхийн), 2) шинжлэх ухааны (математик, байгалийн шинжлэх, технологийн, мэдээлэл, харилцааны технологийн, 3) хөгжил шинэчлэлийн (суралцахуй шинэчлэлийн, санаачилга, ажил хэргийн, 4) хүн, нийгмийн (хувь хүний, нийгэмшихүйн) дөрвөн багц, 8 дэд компетенцийг томъёолон тоонон загварт оруулав (Зураг 2).



### ХЭЛ, СОЁЛ

- Хэлний
- Соёл, түүхийн

### ШИНЖЛЭХ УХААН

- Математик, байгалийн шинжлэх ухаан, технологийн
- Мэдээлэл, харилцааны технологийн

### ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ

- Суралцахуй, шинэчлэхүйн
- Санаачилга, ажил хэргийн

### ХҮН, НИЙГЭМ

- Хувьхүний
- Нийгэмшихүйн

*Зураг 2. Монгол суралцагчийн компетенцийн тоонон загвар*

МкКлеландын онолын дагуу компетенци тус бүрт харгалзах мэдлэг, чадвар, хандлагаар тодорхойлж өгсөн. Энэхүү загварын компетенцийн “Хөгжил шинэчлэл” багцын “Суралцахуй, шинэчлэхүйн” компетенцийн мэдлэг, чадвар, төлөвшлийг хэрхэн тодорхойлсныг жишээлэн харуулья ([Оюунцэцг Н ба бусад, 2017](#)).

### Багц 3: Хөгжил, шинэчлэл

#### K5: Суралцах, шинэчлэхүйн компетенци

21 дүгээр зуунд амьдрал, ажлын орчин улам бүр өрсөлдөөнтэй, төвөгтэй болж байгаа учир хүүхэд, залуучуудыг бэлтгэхэд тэдэнд бүтээлч байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, харилцааны соёл, хамтын ажиллагаа чухлаар шаардагдаж байна. Бүтээлч байдал нь чөлөөтэй сэтгэх, шинийг сэдэж санаачилахад суурь дэвсгэр нь болдог. Шүүмжлэлт сэтгэлгээ нь үр дүнтэй үндэслэл, системт сэтгэлгээг ашиглах, шүүж үзэх, шийдвэр гаргах мэдлэг, чадварыг багтаана. Суралцах нь бие даан буюу бүлгээр суралцах үйл явцыг эхлүүлэх, зохион байгуулах, энэ явцад өөрийнхөө суралцах үйлийг цаг хугацаа, мэдээллийн талаас үр дүнтэй удирдах чадвар юм.

Энэ компетенци нь суралцагчаас амжилттай суралцахын тулд өөрийнхөө суралцах үйл явц, хэрэгцээ хийгээд боломжийг тодорхойлох арга замыг мэдэх, саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх зэрэг суралцагчийн мета танин мэдэхүйд чухал үүрэгтэй болно. Энэ нь шинэ мэдлэг, чадвар эзэмших, боловсруулах, ашиглах болон удирдамж зөвлөгөөг эрж хайж, ашиглана гэсэн үг. Мета танин мэдэхүйн мэдлэгтэй байх нь тухайн орчны хүнд тасралтгүй өөрчлөлтийн эсрэг хамгийн сайн хамгаалалт болж өгдөг. Суралцах компетенци нь суралцагч мэдлэг, чадвараа гэр орон, боловсрол эзэмших орчин зэрэг янз бүрийн нөхцөлд ашиглахад өмнөх суралцаж байсан болон амьдралын туршлагадаа тулгуурлахыг шаарддаг. Хувь хүний сэдэл, өөртөө итгэх итгэл нь энэ компетенцид шийдвэрлэх нөлөөтэй.

Энэ компетенцид харгалзах үндсэн мэдлэг, чадвар, төлөвшил:

### Мэдлэг

- Суралцах арга барил болон шинжлэх ухаанч арга барил
- Өөрийн сонирхол, чадвар, суралцах стратеги
- Зорин суралцаж байгаа боловсрол болон ажил, мэргэжилд тавигдах шаардлага
- Шинэчлэлийн ач холбогдол
- Бүтээлч байдал, шинэчлэл нь бэрхшээл, эрсдэлтэй ч үүнийг суралцах боломж болдог тухай
- Шинэ санаа хэрэгжүүлэхэд шаардагдах амьдралын бодит боломж

### Чадвар

- Шинэ мэдлэгийг зорилготой, өөрийн удирдлагатай эзэмших
- Өөрийнхөө суралцаж буй үйл явцыг удирдах, хувийн сахилга баттайгаар суралцах
- Суралцаж буй үйл явц, зорилго, туршлагадаа шүүмжлэлтэй хандаж, дүгнэлт хийх
- Суралцах үйл явцад бусадтай хамтран ажиллах, янз бүрийн бүлгийн давуу талыг ашиглах, сурч мэдсэн зүйлээ бусадтай хуваалцах
- Өөрийн суралцах үйл явцыг зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг авах боломжийг эрж хайх
- Суралцах үйл явц, мөн саад бэрхшээл, өөрчлөлтийг зохицуулан даван туулах
- Бүтээлч амжилтаа сайжруулахын тулд өөрийн санаагаа эргэцүүлэн бodoх, сайжруулах, боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх, үнэлэх
- Инновацийг бий болгоход бүтээлч санаа сэдэх, бодитой, ашигтай хувь нэмэр оруулах
- Тухайн нөхцөл байдалд үр дүнтэйгээр задлан шинжлэх, нотолгоо, баримт, ойлголт, төсөөллөө хянаж үзэх
- Янз бүрийн үзэл бодлыг тодруулж, илүү сайн шийдэл гаргахад ач холбогдолтой асуудлыг тодорхойлох
- Хамгийн оновчтой шийдэлд хүрэхийн тулд дэмжлэг болохуйц асуудлуудыг олон талаас авч үзэх, асууж тодруулах, харьцуулах
- Ерөнхий үр дүнг бий болгоход цогц систем доторх бүх хэсгүүд нь хоорондоо хэрхэн нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийх, үр дүнтэйгээр задлан шинжлэх, нотолгоо, баримт, ойлголт, төсөөллөө хянаж үзэх, томоохон хувилбарт санаануудыг судлах, дүгнэж үзэх

### **Төлөвшил**

- Суралцах сэдэл, тэмүүлэлтэй, өөртэй итгэлтэй
- Тэвчээр, махруу зантай
- Амьдралын ямар ч нөхцөлд суралцах хүсэл эрмэлзэлтэй
- Өөрийгөө суралцах үйлд дайчилдаг, суралцах боломжуудыг эрэлхийлдэг
- Суралцах үйлийг насан туршийн үйл явц гэж үздэг
- Ирээдүйдээ ахиц дэвшил гаргахын тулд өнгөрсөн үедээ дүгнэлт, шүүмжлэлтэй ханддаг
- Шинийг сэдэж, санаачилдаг

### **K6: Санаачилга, ажил хэргийн компетенци**

Санаагаа ажил хэрэг болгох хувь хүний чадвар бол санаачилга, ажил хэргийн компетенци юм. 21 дүгээр зуунд чухлаар тавигдаж байгаа энэ компетенцид тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтээлч сэтгэлгээ, инноваци, эрсдэл хүлээхэд бэлэн байдал болон төслийн ажлыг төлөвлөх, удирдан зохион байгуулах чадвар багтана.

Энэ компетенци нь хувь хүний амьдралыг зохион байгуулалттай болгож, хүн ирээдүйд чиглэсэн чиг хандлагыг авч үздэг болохын зэрэгцээ хувь хүний өөдрөг үзэл, чадавхид сайнаар нөлөөлнө. Ажил хэргийн мэдрэмж нь хувь хүнд зөвхөн гэр орон, өдөр тутмын амьдралд төдийгүй ажлын байрны орчин нөхцөлийг мэдрэх, боломжийг олж хараад туслахаас гадна нийгмийн болон худалдааны ажил эрхлэх хүмүүст шаардлагатай илүү нарийн ур чадвар, мэдлэг эзэмшихэд суурь нь болж өгдөг. Ёс зүйн үнэт зүйлсийн талаарх ойлголт энэхүү компетенцийг дэмжихэд тустай.

Энэ компетенцид харгалзах үндсэн мэдлэг, чадвар, төлөвшил:

### **Мэдлэг**

- Хувийн болон суралцах үйлийн боломж
- Орчин тойрны хүмүүсийн ажил, амьдралын бодит байдал
- Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил
- Сорилт, бэрхшээлийн талаарх ойлголт
- Сургууль, байгууллага, аж ахуйн нэгжийн ёс зүйн хэм хэмжээ
- Бусдыг манлайлж, үлгэрлэх боломж
- Төсөлт ажил

### **Чадвар**

- Шинэ санаа сэдэж, санаагаа бодитойгоор хэрэгжүүлэх
- Асуудлыг шийдвэрлэх арга замуудыг олох
- Манлайлах
- Алсыг хараатай шийдвэр гаргах
- Бэрхшээл, өрсөлдөөний дарамттай нөхцөлд ч зорилго, зорилтоо биелүүлэх
- Зорьсон үр дүндээ хүрэхийн тулд ажлаа тэргүүнд тавих, төлөвлөх, удирдах
- Ажлын үр дүнд хариуцлага хүлээх
- Хэрэгцээтэй нөөц бололцоогоо тодорхойлох, үнэлэх
- Бүтээлч байдал, асуудлыг шийдвэрлэх чадвараа тасралтгүй сайжруулах

- Өөрийн давуу болон сул талыг тодорхойлох
- Эрсдлийг үнэлэх, бууруулах
- Төслийг төлөвлөх, зохион байгуулах, хувь нэмрээ оруулах, удирдах, үнэлэх

## **Төлөвшил**

- Бүтээлч, сэдэл тэмүүлэлтэй
- Санаачилгатай
- Аливааг сонирхож, сониуч ханддаг
- Шүүмжлэлт, ажил хэрэгч сэтгэлгээтэй
- Бие даасан
- Шийдэмгий
- Хувийн болон хамтын зорилгыг хэрэгжүүлэхэд хүч чадвараа дайчилдаг
- Шүүмжлэлд эерэгээр ханддаг
- Эхэлсэн ажлаа хариуцлагатай, үр дүнтэй дуусгадаг

## **Дүгнэлт**

1. “Компетенци” нь мэргэжлийн мэдлэг, оюуны чадвараар хязгаарлагдахгүй, сурч мэдсэн зүйлсээ ажил, амьдралдаа ашиглах чадвар, амьдралын ээрэг хэвшил дадал, ёс суртахуун, зан чанар, бусадтай харилцаж, бусдын дунд сурч, ажиллаж, амьдрах чадвар, дотоод сэдэл тэмүүлэл, сонирхол зэргийг агуулсан цогц ухагдахуун юм.
2. 21 дүгээр зууны бүх шатны боловсролын зорилго, зорилт нь хувь хүн шинэ зуунд сурч амьдрахад шаардлагатай насан туршийн боловсролын компетенцийг төлөвшүүлэхэд чиглэгдэж байна.
3. Бид дэлхийн чиг хандлага, өөрийн орны онцлог байдлыг харгалзан үзэж, судалгаанд суурилсан 21 дүгээр зууны монгол суралцагчийн эзэмших 4 багц, 8 компетенцийг багтаасан “Тоонон” загварыг боловсруулж, тайлбарлалаа. Энэхүү загвар нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн бүх түвшний боловсролын зорилтод хамаарна. Компетенцийн загварыг боловсролын түвшин (СӨБ, бага, суурь, бүрэн дунд, дээд гэх мэт)-д нарийвчлан буулган боловсруулж хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

## **Ном зүй**

Очирбат П. ба бусад, (2004), Тогтвортой хөгжил, (Багийн ном), Улаанбаатар

Оюунцээг Н, Норжхорлоо Н, Сарангэрэл Д ба бусад. (2017). “21-р зууны монгол суралцагчийн компетенцийн загвар”. Гэрээт ажлын тайлан, БХ. УБ.,

Хулдорж Б., (1999), “Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн МХ-21 хөтөлбөр”, УБ.

ЮНЕСКО, (2015), Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр, <http://www.un-mongolia.mn/new/wp-content/uploads/2012/10/SDGs-Resolution-adopted-by-UN-GA-Mongolian-Version.pdf>

ЮНЕСКО (2016), Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн 4-Боловсрол-30-ийг дэлгэрүүлж ойлгох нь, гарын авлага,  
[Education30,https://www.facebook.com/UNYAPmn/photos/pb.169416679753662.2207520000.1505644938./183824701646177/?type=3&theater](https://www.facebook.com/UNYAPmn/photos/pb.169416679753662.2207520000.1505644938./183824701646177/?type=3&theater)

- ЮНЕСКО, (2017), Боловсролын тухай дахин эрэгцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг юу?, ШУТЫС, олон улсын боловсрол судлалын төв, УБ.
- Boyatzis, R. E. (2008). *Competencies in the 21st century*. *Journal of Management Development*, 27(1), 5-12.
- Caupin, G., Knoepfel, H., Koch, G., Pannenbäcker, K., Pérez-Polo, F., & Seabury, C. (2006). *IPMA Competence Baseline*. Nijkerk: International Project Management Association.
- European Union, KEY COMPETENCES IN EUROPE: OPENING DOORS FOR LIFELONG LEARNER, Recommendation of the European Parliament and of the Council of 18 December
- Hoffmann T. (1999). "The meanings of competency", *Journal of European Industrial Training*, Vol. 23 Issue: 6, pp.275-286, <https://doi.org/10.1108/03090599910284650>
- McClelland, D. C. (1973). Testing for competence rather than for intelligence. *American Psychologist*, 1-14.
- Morgan W.J and White I. (2013). *Looking backward to see ahead: The Faure an Delors report and the post-2015 development agenda*. (Ирээдүйг харахын тулд эргэж нэг харах: Фор, Делорын илтгэл ба 2015 оноос хойшиих хөгжлийн хөтөлбөр) *Zeitschrift Weiterbildung*, No.4, pp 40-43
- OECD, 2005, *Competency Category*, *OECD\_Competencies\_35070367.pdf*
- Partnership for 21 st century Learning, *Framework for 21st century Learning*, *21st Century Student Outcomes and Support Systems* <http://www.p21.org/>
- Spencer, Lyle M. & Signe M. Spencer (1993), *Competence at Work - Models for Superior Performance*, John Wiley & Sons,
- Tawil S., Cougoureux M., (2013), *Revisiting Learning: The Treasure Within—N 4—Assessing the impact of the 1996 'Delors Report'*, UNESCO
- Teodorescu, T. (2006). Competence versus competency: What is difference? *Performance Improvement*, 45(10), 27-30.
- The American Heritage Dictionary of the English Language*. (2006). Fourth Edition: Print and CD-ROM Edition Subsequent Edition.
- Toward Defining 21st Century Competencies for Ontario, Winter 2016 edition, Ontario
- UNESCO (1996), *Learning: The Report to UNESCO of the International Commission on Education for the Twenty first Century*, UNESCO publishing
- UNESCO (1997), *International Standard Classification of Education, ISCED 1997*, [http://www.unesco.org/education/information/nfsunesco/doc/isced\\_1997.htm](http://www.unesco.org/education/information/nfsunesco/doc/isced_1997.htm)
- UNESCO (1999), *UNESCO/OECD World Education Indicators Programme, investing in education analysis of the 1999 world education indicators*
- UNESCO (2000), *The four pillars of learning*, <http://www.unesco.org/new/en/education/networks/global-networks/aspxnet/about-us/strategy/the-four-pillars-of-learning/>
- UNESCO, (2013), *Toward Universal Learning A Global Framework for Measuring Learning*, report №2, center for Universal Education at Brookings
- UNESCO, (2013), Bangkok Office, ERI-Net (Asia-Pacific Education Research Institutes Network), *TRANSVERSAL COMPETENCIES IN EDUCATION POLICY& PRACTICE, (PHASE I)*,
- UNESCO, (2015), *Sustainable Development Goal 4 and its targets*, <https://en.unesco.org/node/265600>
- UNESCO, (2015), *Rethinking Education: Towards a global common good?*, printed by UNESCO in France
- UNESCO (2016), *Education for people and planet: Creating sustainable futures for all*, *Global education monitoring report, second edition*, printed by UNESCO in France
- Vikram S.Ch.& Sandeep S. (2014). *Understanding Competencies and Competency Modeling — A Literature Survey*. *IOSR Journal of Business and Management (IOSR-JBM)* e-ISSN: 2278-487X, p-ISSN: 2319-7668. Volume 16, Issue 1. Ver. I (Jan. 2014), PP 14-22

## **ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ ДАХЬ ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООГ ХЭМЖИХ ЗАГВАРЫН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ**

Д.Түмэнбаяр<sup>1</sup>, Б.Отгонжаргал<sup>2</sup>, Д.Цэцэгдэлгэр<sup>3</sup>

<sup>1</sup> МУИС-ийн ШУС-БУСалбар, Математикийн тэнхим, багши

<sup>2</sup> МУИС-ийн ШУС-БУСалбар, Математикийн тэнхим, Багши-Боловсрол IV түвшин, оюутан

<sup>3</sup> БСШУСЯ-ны харьяа Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн

### **Abstract**

*The purpose of this study was to investigate the reliability for Family Involvement Questionnaire (FIQ) for use in high school settings (11<sup>th</sup> -12<sup>th</sup> grade). After the FIQ was redesigned for use in the high school setting, 50 parents completed the questionnaire. Internal consistency for the 35 item questionnaire was high ( $\alpha = 0.789-0.879$ ). The findings show that mothers ranked more high for HBPI and PCHC as compared to fathers. And fathers ranked more high for SBPI, PTC, SPC as compared to mothers. However, there is no significant difference between fathers and mothers involvement.*

**Түлхүүр үг:** Хүүхдийн боловсрол дахь эцэг эхийн оролцоо, гэр дэх оролцоо, багши-эцэг эхийн харилцаа, сургуулийн талаарх эцэг эхийн хандлага, итгэл үнэмшил, сургуулийн үйл ажиллагаан дахь оролцоо, хүүхэд эцэг эхийн харилцаа

## **Үдиртгал**

Хүүхдийн боловсрол дахь эцэг эхийн оролцоо ба суралцагчийн сурах арга барил, стратеги, хандлага нь суралцагчийн академик амжилтад нөлөөлөх хүчин зүйлүүд бөгөөд сургууль, боловсролын бодлого дахь чухал сэдвүүдийн нэг юм. Хүүхдийн боловсрол дахь эцэг эхийн оролцоо нь олон хүчин зүйлээс хамаарах ухагдахуун бөгөөд олон хэлбэртэй байдаг. Тухайлбал, хүүхдийн боловсролын амжилтын талаарх эцэг эхийн хүлээлт, гэрийн даалгаварт оролцох эцэг эхийн оролцоо, гэртээ танин мэдэхүйн идэвхтэй үйл ажиллагаа явуулах, эцэг эх-хүүхдийн харилцаа холбоо (сургууль, найз нөхдийн тухай, эрүүл мэндтэй холбоотой зан үйл), мөн сургуулийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох зэрэг багтана (Epstein, 1995, Fan & Chen, 2001; Hoover-Dempsey & Sandler, 1995, 1997, Hoover-Dempsey & Sandler, 2005; Sheldon & Epstein, 2005; Walker, Wilkins, Dallaire, Sandler, & Hoover-Dempsey, 2005).

Судалгааны болон практик салбарт аль алинд нь эцэг эхийн оролцоог илүү ойлгомжтой болгож, боловсрол, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийн тулд эцэг эхийн оролцооны загваруудыг боловсруулсан байдаг.

Hoover-Dempsey, Sandler (1995) нар эцэг эхийн оролцооны онолын загварыг таван үе шаттайгаар боловсруулсан ба бусад судлаачидтай хамтран уг загварыг үргэлжлүүлэн судалж, 2005 онд дахин сайжруулсан (Walker, J. M. T., Wilkins, A. S., Dallaire, J. R., Sandler, H. M., & Hoover-Dempsey, K. V, 2005). Сайжруулсан загварыг доор харууллаа.

1. Сургуулийн үйл ажиллагаанд оролцож эхлэх анхны шийдвэр
  - Сургуульд хүүхдээ сургах хариуцлагын талаар мэдрэмж
  - Хүүхдийнхээ академик амжилтад хувь нэмрээ оруулах чадварын талаарх итгэл үнэмшил
  - Сургуулийн зүгээс ирэх урилгыг хүлээн авах ойлголт, мэдрэмж
  - Амьдралын хүрээлэл, нөхцөл байдлын талаарх ойлголт, мэдрэмж
2. Эцэг эхийн оролцооны сонголт
  - Байршил (гэрийн эсвэл сургуулийн)
3. Сурагчийн (хүүхдийнхээ) боловсролын процесс (гаралт), үр дүнд нөлөөлөх механизмууд
  - Туслах, бататгах
  - Зааварчилгаа өгөх
4. Зохицох/Дамжуулах хувьсагчууд
  - Хүүхдийн хөгжилд тохирохуйц оновчтой стратегийг ашиглах
  - Эцэг эхийн зан үйл, төлөв ба сургуулийн хүлээлт хоорондын тохироог бүрдүүлэх, зохицуулах
5. Сурагчийн үр дүн
  - Чадварууд ба мэдлэг
  - Сургуулийн амжилтын талаарх сурагчийн өөрийн үнэлээмж

McNeal (1999) нь хүүхдийн боловсрол дахь эцэг эхийн оролцоо нь гурван механизмаар сурагчдын үр дүнтэй байдалд нөлөөлдөг гэж үзсэн. Эхний механизм, нийгэмшүүлэх буюу

гэрийн даалгаварыг хянаж хийлгэж байх, эцэг эхчүүд хүүхдүүддээ сургуульд суралцахын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн санаа өгөх бөгөөд эцэг эхийн гэр бүл дэх оролцоо гэсэн үг юм. Сургуулийн үйл ажиллагаанд оролцох замаар хүүхдэдээ тавих хараа хяналтыг бий болгох нь хоёр дахь механизм юм. Үүнийг сургууль суурилсан оролцоо гэж ойлгож болно. Сургуульд суурилсан оролцоо нь эцэг эхчүүдэд багш, бусад эцэг эхчүүдтэй харилцах харилцааг хөгжүүлэх боломжийг олгож, тэдний зан байдлыг хэлэлцэж, тэднээс суралцах боломжийг олгодог. Сүүлийн механизм нь сургуулиас мэдээлэл авах замаар, сурагчдыг хянах оролдлого хийх явдал юм. Жишээлбэл, энэ механизмаар эцэг эхчүүд хүүхдийнхээ зан үйлийн асуудлыг мэдэх боломжтой ба шийдлүүдийн талаар илүү сайн мэдээлэлтэй байх болно. McNeal-ийн онол нь гурван механизмын өөр өөр үр дүнг тодорхойлдог. Эдгээр гурван механизм нь сурагчдын танин мэдэхүй болон зан төлөвт шууд нөлөөлдөг (McNeal 1999). Сургуулийн үйл ажиллагаатай нарийн нягт холбоотой эцэг эхчүүд сурагчдын зан байдал, гэрийн даалгавар, гэрийн даалгаварт хэрхэн туслах талаар суралцдаг. Тэд бас хүүхдийнхээ суралцах чадварыг дээшлүүлэхэд тохирсон, оновчтой сонголтуудын талаар бусад эцэг эхчүүдээс суралцдаг. Үүний зэрэгцээ багш нар сурагчдынхаа эцэг эхийн хүлээлтийг мэддэг.

Grolnick болон Ryan нарын (1989) онол нь "эцэг эхийн хэв маяг" -ыг эцэг эхийн гэр бүл дэх үр нөлөөг анхаардаг. Энэ онолын хүрээнд эцэг эхийн оролцооны гурван хэлбэр нь суралцагчийн зан төлөв, сурлагын амжилтанд чухал үүрэгтэй. Эхнийх нь сурагчид бие даан асуудлыг шийдэх, шийдвэр гаргахад оролцох оролцоог дэмжих явдал юм. Хоёр дахь хэв маяг нь эцэг эхийн шууд оролцоо буюу эцэг эх хүүхдийнхээ амьдралд идэвхтэй оролцож, мэдлэгтэй, хэр зэрэг сонирхолтой байгааг илэрхийлдэг. Сурагчдад эерэг нөлөөлөл үзүүлж болох эцэг эхийн оролцооны гурав дахь хэв маяг нь гэрийн даалгавар эсвэл сургуулийн бусад асуудлын талаархи бүтэц зохион байгуулалт (жишээ нь: тодорхой бөгөөд байнгын дүрмийг биелүүлэх) хийх явдал юм. Эдгээр үр дүнг сургуулийн сурагчдын гүйцэтгэлээр тайлбарласан болон урт хугацааны туршид эцэг эхийн оролцоо нь сурагчдын суралцах үйлст эерэг нөлөөтэйг харуулсан судалгааны үр дүн олон бий (Patall нар, 2008).

Хүүхдийн боловсрол дахь эцэг эхийн оролцооны түгээмэл загварыг 1990-ээд оны эхээр Epstein боловсруулсан (Epstein 1992, Manz нар, 2004). Энэ загвар нь ихэвчлэн сургуулийн үйл ажиллагаанд санаачлагатай оролцдог эцэг эх рүү голчлон чиглэсэн. Гэхдээ энэ нь сурагчдыг сургахад бүхэлд нь хамаатай бөгөөд эцэг эх, гэр бүл, сургууль, хамт олон нь хүүхдүүд суралцахад эерэг орчныг бий болгохын төлөө хамтран ажиллах ёстой (Mattingly нар, 2000). Epstein (1992) нь эцэг, эхийн оролцоог илэрхийлж болох зургаан хэв маягийг тодорхойлсон. Эдгээр нь Bakker болон бусад судлаачдын тодорхойлсон эцэг эхийн оролцооны гурван төрлийг агуулдаг (Bakker, 2007). Epstein (1992) эцэг эх, сургууль, багш нарын оролцооны зургаан хэлбэрийг авч үзсэн. Үүнд:

- **Эцэг эхийн хайр халамж.** Гэр бүлийн дэмжлэг, хүүхэд-өсвөр үеийнхний хөгжлийн талаарх ойлголт, нас болон суралцах түвшин бүрт тохируулан суралцах нөхцөл боломжийг бий болгох, гэр бүлийн хүрээн дэх соёл, хүмүүжил, хүүхдийн зорилгыг ойлгоход туслах
